



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/090/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум 2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamd@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	10,500.0	10,500.0
Бараа материал	16,133.2	63,477.2	47,344.0
Үндсэн хөрөнгө	1,710,362.2	1,792,829.7	82,467.5
Нийт хөрөнгө	1,726,495.4	1,866,806.9	140,311.5
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,726,495.4	1,866,806.9	140,311.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,726,495.4	1,866,806.9	140,311.5

Авлага: Тайланд оны эцэст нэмэлт санхүүжилтийн дансанд байсан өвс тэжээлийн фондын 10,500.0 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Бараа материал: Сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 29,990.0 төгрөгийн өвс, тэжээл, 20,000.0 мянган төгрөгийн сургалт, сурталчилгааны материалыг бүртгэсэн нь бараа материалын дансны үлдэгдэл 47,344.0 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө: Төсвийн хөрөнгөөр 37,329.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 84,737.2 мянган төгрөг, Онцгой байдлын ерөнхий газраас шилжүүлсэн 78,000.0 мянган төгрөгийн авто машин, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 28,600.3 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус хүлээж авсан байна. Тайланд онд нийт 151,230.7 сая төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхөж 0.0 төгрөгийн үлдэгдэлтэй болсон нийт 212,234.0 мянган төгрөгийн анхны үнэтэй 77 ширхэг хөрөнгө байна.

Эдгээр хөрөнгүүдийг дахин үнэлж, хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх зөвлөмж хүргүүлэв.

Засгийн газрын хувь оролцоо: Засгийн газрын хувь оролцоо данс нь тайланд оны үр дүн буюу 140,311.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 966,083.7 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх удирдлага	80101 Үндсэн үйл ажиллагаа	786,570.1	783,114.5	3,455.6	99.1%
2		80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	110,875.0	105,616.1	5,258.9	99.4%
3		80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,601.8	4,601.6	0.2	98.5%
4		82801 Улсын баяр наадмын зардал	2,500.	2,500.0	0	100%
5		80305 Биеийн тамир уралдаан тэмцээн	1,000.0	975.0	25.0	97.5%
5	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	30,000.0	29,961.9	38.1	100%
6		80918 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	0.0%
7	Байгаль хамгаалах нөхөн сэргээх	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	44,208.5	39,314.6	4,893.5	92.9%
		Нийт	979,755.4	966,083.7	13,671.3	99.0%

5.1 Зөвлөмж

5.1.1. Үндсэн хөрөнгийн бүртгэл

Илрүүлэлт: Улаан-Уул сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхөж 0.0 төгрөгийн үлдэгдэлтэй болсон нийт 212,234.0 мянган төгрөгийн анхны үнэтэй 77 ширхэг хөрөнгө байна. Эдгээр хөрөнгүүдийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй бөгөөд “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн бүртгэл, эд хөрөнгийн тооллогын үр дүнг үндэслэн тухай бүр байгууллагын хөрөнгийг үнэлж, цэгцэлж ажиллах

5.1.2. Ахмадын сан

Илрүүлэлт: Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ нь ахмадын сан байгуулаагүй бөгөөд 2024 онд ахмадуудад зориулсан үйл ажиллагаанд нийт 300.0 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална”, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-тай нийцэхгүй ба “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагад ажиллаж байсан ахмадуудад зориулж төсөв зарцуулахдаа Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын дагуу ахмадын сан байгуулж тус сангийн журмыг мөрдөж ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн бүртгэл цэгцлээгүй	1	0.0					1	0.0				
Ахмадын сан байгуулаагүй	1	0.0					1	0.0				
Дүн	2	0.0	0	0.0	0	0.0	2	0.0	0	0.0	0	0.0